

Маягт СЗХ04008

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Тээвэрлэгчийн хариуцлагын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэх батлах тухай		2021-02-05		ЗТ-21/02-010	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Тээвэрлэгчийн тээж яваа ачаа					
	Даатгалын үндсэн эрсдэл	Ачаа тээвэрлэх үедээ санамсар, болгоомжгүй үйлдэл					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.4%-1%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

## ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, ууршилт зэрэг тээвэрлэгдэж байгаа эд хөрөнгө, бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол;
2. Шалган турших зорилгоор эсвэл санаатайгаар ачааллыг хэтрүүлэх болон хэвийн бус байдлыг буй болгосон аливаа тохиолдлоос үүссэн хохирол;
3. Даатгуулагч, түүний ажилтны гэмт хэргийн шинж чанар, зорилготойгоор үйлдсэн үйлдлийн улмаас учруулсан аливаа хохиролд;
4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлд гарсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн алдагдалд;
5. Даатгалын тохиолдлын улмаас газар, шороо, хөрс, агаар, газрын хэвлийн болон байгаль орчинд учирсан хохиролд;
6. Гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна учирсан аливаа хохиролд;
7. Даатгуулагч, түүний ажилтны согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үед хийсэн үйлдлийн улмаас үүдсэн хохиролд;
8. Тээвэрлэлтийн үйлчилгээний хөлс;
9. Тээвэрлэлтээс өмнө гарсан хохирол буюу эвдэрэлтэй байсан ачаа бараа тээж явсан тохиолдолд;
10. Хадгалалтын горим, хугацаа, үйлдвэрлэлийн гэмтэл гологдол зэргээс үүссэн хохирол;
11. Их хэмжээний өргөн хэрэглээний барааны хувьд учирсан хохирлын хэмжээ даатгалын нийт үнэлгээний 3 хувиас хэтрээгүй бол;
12. Сав баглаа боодол, ачааны бэхэлгээний шаардлага хангаагүйгээс үүссэн хохирол, гэмтэл;
13. Хамгаалалтын болон зөөх зориулалтаар хийгдсэн гадны нөлөөнөөс хамгаалсан сав баглаа боодол гэмтэхэд;
14. Худалдааны бус зориулалттай ачаа, барааны шошго, сав баглаа боодолд учирсан хохирол;
15. Тээвэрлэгчийн санхүү төлбөрийн чадваргүйгээс үүдсэн хохирол, алдагдал;
16. Ачаа саатсанаас болж учирсан хохирол;
17. Бүрэн бус, шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр тээвэрлэснээс болж учирсан хохирол;
18. Даатгуулагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний дагуу төлөгдөх анз, дэнчин, баталгаа, эрх бүхий байгууллагаас ногдуулсан торгууль, төлбөр;
19. Хулгай, дээрмийн эрсдэлийн улмаас гарсан хохирол;
20. Өөрийн тээврийн хэрэгсэлд учруулсан хохирол;
21. Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирол;
22. Даатгалын гэрээ болон баталгаанд зааснаас өөр тээврийн хэрэгсэл жолоодож явсан болон жолоодох эрхгүй этгээд жолоодож явснаас үүссэн хохирол;
23. Хууль тогтоомжид заасан бусад.